



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/864

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ковид -19" цар тахлын үед аймгийн нөөцөд мах нийлүүлэх ШХА/2020-38 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ганхуяг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Цэргийн штабын дарга

Гишүүд:

Д. Мөнхжаргал - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнс,  
худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ, нийтийн хоол  
хариуцсан мэргэжилтэн

М.Пүрэвхүү - Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн  
улсын байцаагч

Х.Одгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Цэргийн штабын офицер

Ж.Энхмандал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, аж ахуйн тасгийн дарга

Х. Болормаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав


Нарийн бичгийн  
дарга: Ц.Пүрэвсүрэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Zax A/864 Ch  
02 4296

2. “Баавай өвөө” ХХК, “Монголиан Каттл” ХХК-ний нийлүүлсэн бүтээгдэхүүнийг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ганхуяг /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН